



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар

1/324

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.14 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах бохирын цооногтой төрийн байгууллагуудын бохирыг соруулах ажлын хүрээнд Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий компанийн судалгааг гарган, сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын албаны дарга

Нарийн бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг дүүргийн Засаг даргад танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Ж.Тамир)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010977